



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/589

Эрдэнэт

Сургалтад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 "а", 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.7 дахь заалт, Аймгийн ИТХ-ын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит VI хуралдааны 6/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Эмч" дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн IX хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. "Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах" төслийн хүрээнд эх барих эмэгтэйчүүдийн сургагч багшаар бэлтгэгдсэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Эмнэл зүйн сургалтын зөвлөлийн дарга Б.Одонтунгалаг нь Бүгд Найрамдах Япон улсад 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай ажил мэргэжлийн туршлага солилцох сургалтад суралцах тул санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 1 000 000 / Нэг сая / төгрөгийг аймгийн Засаг даргын 2018 оны "Эмч" хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/194 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд болон 3 дахь шатлалын эмнэлэгт эмч, эмнэлгийн ажиллагсадын ажил мэргэжлийн туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх" зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг зохион байгуулан явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэн хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Бүсийн оношлогоо эмчилгээний төв /н.Батсүх/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



D:(Zahiramj) A-4 doc

0201802119